

## **Мэдээлэл, Харилцаа Холбооны технологийн тухай хууль (суурь хууль)-ийг боловсруулах үзэл баримтлалын асуудлууд**

### **Хуулийн зорилго:**

- МХХТ-ийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих замаар мэдээллийн нийгмийг байгуулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгэм-эдийн засгийн хөгжлийг хангах

### **Өнөөгийн байдал:**

Өнөөгийн байдлаар Харилцаа, Холбооны тухай хууль үйлчилж байгаа ба Мэдээллийн Технологийн хуулийн төслийг боловсруулаад байгаа. Харилцаа, Холбооны тухай хууль болон Мэдээллийн Технологийн хуулийн төслийг шинжилж үзэхэд өнөөгийн шаардлагаас хоцорсон, дутуу зохицуулсан олон асуудлууд байна. Тухайлбал:

- чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, бүх нийтийн (универсаль) үйлчилгээ, хандалт, либералчлалын утгыг хууль болон хуулийн төсөлд тусгаж өгөөгүй, тиймээс үзэл баримтлал нь орчин үеийн шаардлагыг хангаж чадаагүй, үүний улмаас хуулийн зорилго буруу томъёологдсон байна.
- Орчин үеийн шинэ технологийн хөгжлийн нөлөөллөөр харилцаа холбоо, Цахилгаан холбооны салбарт ажиглагдаж байгаа либерализаци, бүтцийн өөрчлөлтийн хандлагыг Харилцаа Холбооны тухай хууль тусгаж чадаагүй байна.
- Энэ хуулиудад хэвтээ чиглэлд интеграцчилах хандлага огт тусгагдаагүй, босоо чиглэлд уялдуулсан хувьчлалыг баримталж байгаа нь маш том алдаа.
- Монопольчлол үүсэх боломж нээлттэй байна. Хуулинд үүнийг сэргийлэх заалтууд маш бага.
- Эдгээр хуулиудад өрсөлдөх чадварын зарчмыг тусгаагүйгээс монополь компаниуд бусдыгаа хязгаарлах аюул оршсоор байгаа. Харилцаа холбооны салбарын харилцааг зохицуулахад чиглэгдсэн, түүнд хамааралтай хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар одоо үйлчилж буй хуулиудад зах зээлийн ноёрхлыг зохицуулах үзэл баримтлал сайн тусгагдаж чадаагүй байна.
- Хуулиудад заагдсан “зүй ёсны монополь”, “ноёрхогч”, “давамгайлагч” хэмээх ойлголтын дагуу бараа, үйлчилгээний зах зээлийг тодорхойлох нь төрийн зохицуулалтын хүрээн дахь асуудлыг хүндрүүлж байна. Зохицуулах байгууллагаас харилцаа, холбооны салбарын зах зээлийг шинжлэх үүргийг

хуулиар тогтоогоогүй байна. Одоо үйлчилж байгаа хуулинд харилцаа холбооны зах зээлийг ангилсан үндсэн зарчим нь сүлжээний ангилалд тулгуурласан байна. Гэтэл үйлчилгээ дээр суурилсан ямар ч ангилал байхгүй байна. Түүнчлэн технологи, хэрэгсэл, дэд бүтэц дээр суурилсан ангилал огт байхгүй байна. Гэтэл үйлчлүүлэгч гэрээ хийхдээ мэдээлэл хүлээн авах, дамжуулах боломжийг сонирхдог. Энэ үүднээс үзвэл технологи, хэрэгсэл дээр суурилсан ангилал зайлшгүй байх ёстой нь харагдаж байна.

- Харилцаа Холбооны тухай хууль болон Мэдээллийн Технологийн тухай хуулийн төсөлд Технологийн төвийг сахисан байдлыг тусгаж чадаагүй байна. Энэ нь төрийн аль нэг эрх бүхий байгууллага, эрх мэдэлтэн, албан тушаалтан, лобби бүлгийнхэн, ноёлох байр суурьтай байгууллагууд тодорхой технологийг давууд үзэх, тодорхой үйлдвэрлэгчийн эрх ашиг сонирхолыг дээгүүр тавих, улмаар монополь байдал үүсгэх, Монгол улсыг гадаадын тодорхой технологиос хараат байдалд оруулах аюултай.
- Эдгээр хуулиудад хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг хангах, ёс суртахууны хамгаалалт хийх талаар заалт байхгүй. Мөн оюуны өмчийн эрхийг хамгаалах, ялангуяа интернетэд оюуны өмчийг хамгаалах заалт байхгүй байгаа нь цаашид үүсэж болох олон зөрчилдөөн, маргаан, хэргээс сэргийлэх боломжгүй болгож байна.
- Хуулиудад байгаа нэр томъёоны тайлбар нь бүрхэг, маш цөөхөн бөгөөд олон нэр томъёог тайлбарлалгүй орхисон байна.
- Хуулиудад шинээр үүсэн бий болсон, нэмэгдэж буй мэдээлэл, цахилгаан холбооны үйлчилгээ, үйл ажиллагааг хэрхэн яаж тооцох, тогтоох, зөвшөөрөх, тусгай зөвшөөрөл олгох талаар ямар ч заалт байхгүй байна. Үүний улмаас шинэ үйлчилгээ, үйл ажиллагаа гарч ирэхэд түүнийг хааш нь хэрхэн хамааруулах, яаж зохицуулахад хүндрэлүүд үүсэж байна (жишээлбэл МТ-ийн аудит, МАБ-ын аудит, тоног төхөөрөмжийг шалган баталгаажуулах ажиллагаа г.м).
- Үйлчилгээний гэрээгээ операторууд (провайдерууд) боловсруулахдаа баримтлах зарчмуудыг аль ч хуулинд заагаагүй байна. Энэ нь монополь үүсэх, үйлчлүүлэгчдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хөндөх, дураараа авирлах боломжийг бий болгож байна.
- Тусгай зөвшөөрлийг уралдаант шалгаруулалтын (конкурсын) үндсэн дээр, зөвхөн хязгаарлагдмал нөөцтэй үйлчилгээнд олгох, ерөнхий болон нэг бүрчилсэн лиценз

олгох талаар шинэчилсэн зохицуулалт тусгагдаагүй байгаа нь тусгай зөвшөөрлийг олгоход хүнд суртал гарах, шударга өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл болж болно.

- Түүнчлэн дээрх хуулиудад тусгай зөвшөөрөл олгохгүйгээр зөвшөөрөл авах, бүртгүүлэх замаар эрхэлж болох үйлчилгээг тодорхой заагаагүй байна. Тиймээс шинэ технологийг хурдан нэвтрүүлэх, бүх нийтийн хандалт, үйлчилгээг хангах үйлчилгээг шуурхай нээх боломжийг хаахаас гадна тодорхой эрх бүхий албан тушаалтнуудын үзэмжээр асуудлыг шийдэх боломжийг бий болгожээ.
- Эдгээр хуулиудад үнэ тарифын бодлого, өрсөлдөөн, монополийн эсрэг, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар төрийн байгууллагын эрхийг нарийвчлан зааж өгөөгүй байна. Энэ нь дээр дурдсан олон бэрхшээл, зөрчилдөөнийг үүсгэх бас нэг нөхцөл болж өгнө.
- Ямар тохиолдолд дээд үнийн хязгаарыг тусгай зөвшөөрөлд зааж өгөх талаар дээрх хуулиудад заалт байхгүй байна. Энэ нь тодорхой нөхцөл бүрдсэн үед үндэслэлгүйгээр үнээ нэмэх, хэрэглэгчдийн эрх ашиг, сонирхлыг хөсөрдүүлэх боломжийг бий болгоно.
- Хуулиудад харилцаа холбооны зохицуулах хорооны тухай тодорхой зааж өгсөн мөртлөө Мэдээлэл Харилцаа Холбооны Технологийн Газрын тухай ямар ч заалт огт ороогүй байна. Хуулийн эхний хэсэгт төрийн захиргааны байгууллага гэсэн бүрхэг заалтууд байгаа нь энэ салбарыг хөгжүүлэхэд хэн ямар үүрэг хүлээж эрх эдлэхийг тодорхойлоход саад болж байна.
- Орчин үеийн конвергенци, бүх нийтийн хандалт, үйлчилгээний хандлагыг харгалзсан заалтууд огт байхгүй. Мэдээлэл, харилцаа, холбооны үйлчилгээг олон нийтэд хүртээлтэй болгох талаар заалт байхгүй байна.
- Хуулиудад “үйлчилгээ үзүүлэх”, “сүлжээ ашиглах”, “түрээслэх” үеийн баримтлах зарчмуудыг огт оруулаагүй байна.
- Хуулиудад хүчтэй, зүй ёсны монополь байгууллага гэж юу болохыг тодорхойлоогүй байна. Үүнийг “Шударга бус өрсөлдөөний тухай” хуулийн заалт дээр үндэслэн тодорхой, нарийвчлан зааж оруулах шаардлага харагдаж байна.
- Хуулиудад “Техникийн зөвшөөрөл” гэж юу байдаг талаар ямар ч ойлголт оруулаагүй байна.

- Хуулиудад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар ямар ч заалт, ойлголт байхгүй, үйлчилгээний мэдээлэл, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг хамгаалах талаар заалт байхгүй байна.
- Хуулиудад үйлчилгээний талаар талуудын хүлээх үүрэг, эдлэх эрхийг бүрхэг заасан байна. Эдгээрийг нарийвчлан зааж өгөх нь маш чухал ач холбогдолтой.
- Түрээсийн шугамаар үйлчилгээ үзүүлэх нөхцөл, хугацаа, гэрээ байгуулах журам, татгалзах үндэслэл дээрх хуулиудад заагдаагүй байна.
- Хуулиудад хэрэглэгчийн тухай нийтлэх, төрөл бүрийн лавлахад оруулах талаар зохицуулалт байхгүй байна.
- Мөн түүнчлэн хууль хяналт, мөрдөн байцаах байгууллагад мэдээлэл гаргаж өгөх журам тусгагдаагүй, нотлох баримтын тухай ямар ч заалт байхгүй байна.
- Бүх нийтийн үйлчилгээ үзүүлэх талаар үүргийг хуульчлаагүй байгаа нь ирээдүйн хөгжлийн хандлагатай зөрчилдөж байна.
- Дээрх хуулиудад операторуудын хамтын ажиллагаа, гэрээ, үүрэг, төлбөр, үйлчилгээ, маргаан шийдэх, төрийн өмчийн сүлжээнд хандсан төлбөр, хязгаарлалтын талаар ямар ч заалт байхгүй.
- Үйлчилгээний төлбөр, тухайлбал, тарифын мэдэлэл өгөх үүрэг, төлбөр төлөх журам, төлбөрт тавигдах шаардлага, хөнгөлөлт, монополь байгууллагад хандсан нэмэлт шаардлагууд, тариф ашиглах талаар заалтуудыг хуулиудад тусгаагүй.
- Хуулиудад Цахилгаан холбооны сүлжээний терминаль төхөөрөмжүүд, төхөөрөмж нийлүүлэх талаар ямар нэг заалт байхгүй байна. Мөн Радио холбооны талаар заалтууд маш дутмаг, бүрхэг, олон заалт нэмэх шаардлагатай болох харагдаж байна.
- Суурин утасны дугаарыг хуваарилах талаар тодорхой заалтууд байхгүй байна.
- Ямар тохиолдолд үнийн хязгаарлалт хийх тохиолдлуудыг хуулинд огт заагаагүй байна. Энэ нилээд ноцтой цоорхой болжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.
- Аль ч хуулинд нь мэдээллийн нийгмийн асуудлуудыг заагаагүй орхигдуулсан нь “Цахим Монгол” хөтөлбөр, “Цахим сум” хөтөлбөр, “Цахим засаг” мастер төлөвлөгөө болон “Цахим боловсрол”, “Цахим эрүүл мэнд”, “Цахим ардчилал”, “Цахим бизнес” хөгжихөд туслан үйлчилж, зохицуулах боломжийг бий болгож чадахгүй байна.

- Хуулиудад оюуны өмчийн хамгаалалтын асуудлууд огт тусгагдаагүй, зөвхөн зохиогчийн эрхийн тухай хуулинд найдаж орхисон байдал ажиглагдаж байна.
- Хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах ямар ч заалт үгүй байна.
- Аль ч хуулинд Интернетийн агуулгад провайдерийн тавих хяналтын талаар заалт оруулаагүй байна.
- Бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгө дээр тулгуурлан хөдөө орон нутагт үнэгүй терминалууд бий болгох талаар зохицуулалтыг хуулинд зааж өгөөгүй байна.
- Хуулиудад хөрөнгө, татаасын бодлого тусгагдаагүй байна.
- Аль ч хуулинд төр, хувийн салбарын түншлэлийн /Public Private Partnership/ асуудал огт тусгагдаагүй байгаа.
- Хуулиудад жижиг сүлжээний өрсөлдөөнийг төрөөс дэмжих асуудал орхигдсон байна.
- Өөрийн дэд бүтцээ байгуулж буй компанийг төрөөс хэрхэн дэмжих нь тодорхойгүй, энэ талаар ямар нэг заалт хуулиудад ороогүй байна.
- Хуулиудад Утасгүй дэд бүтцийн талаар ямар ч заалт ороогүй байна.
- Радио давтамжийн зурвасыг үнэ хаялцуулан худалдах тухай заалт хуулинд байхгүй байна.
- Орчин үеийн төлбөрт телевиз, хүсэлтээр үзүүлдэг видео /video on demand/-ын талаар ямар ч заалтгүй.
- Үйлчилгээний агуулгыг зохицуулах тухай заалт хуулиудад ороогүй байна.
- Интернетийг зохицуулах талын заалтууд байхгүй /ёс суртахуунгүй, хувийн нууцыг зөрчсөн контентуудыг хориглох, интернетийг татварт хамруулах, татвараас чөлөөлөх, хөнгөлөх г.м./.
- Бага үнэтэй сүлжээ хөгжүүлэх, өөрийгөө зохицуулах зарчмыг захиргааны бүрэн эрхтэй зөв хослуулах, шинэ компанид сувгаа хэрэглүүлж буй компаниудад лиценз татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт стратегийн хөгжлийн баримжаалал хуулиудад огт тусгагдаагүй байна.
- ISP -ууд өөрийгөө зохицуулах хөгжлийн хандлагыг дэмжих зохицуулалт байхгүй гэх мэт зохицуулагдаагүй маш олон асуудал байна.

## Хуулинд нэмж оруулах өөрчлөлтүүд:

- Мэдээллийн Технологийн хуулийн төслийг УИХ-д оруулалгүй, хууль болголгүйгээр “Цахим хэлцлийн тухай” хууль, “Цахим гарын үсгийн тухай” хууль, “Цахим засгийн тухай хууль”-д илүү нарийвчлан тодорхой болгон зохицуулж улмаар “харилцаа, холбооны тухай” хуулиндаа мэдээллийн технологийн асуудлуудыг нэмж оруулах замаар зохицуулах бүрэн боломжтой. МТ-ийн үйлчилгээ, холбогдох институт, электрон хэлцэл, гарын үсэг, засаглалын асуудлыг бүгдийг нь нэг хуулинд тусгах уу, эсхүл бие даасан өөр хуулинд тус тусад нь тусгах уу гэдэг асуудал эндээс урган гарч байна.
- Бүх асуудлыг багтаасан МТ-ийн суурь хууль гаргахыг оролдож, хольж хутгаж, төөрөлдсөнөөс МТ-ийн салбар бүрийг төрөлжүүлсэн тусгай хуулиар зохицуулах Сингапур Малайзийн хандлагын дагуу хуулиудаа боловсруулах нь илүү ойлгомжтой, тохиромжтой санагдана. Харин мэдээллийн технологийн суурь зохицуулалтын асуудлыг “Харилцаа, холбооны тухай” хуулиндаа нэмж оруулах замаар энэ асуудлыг шийдэх боломжтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн дээрх гурван гол асуудал болох *электрон арилжаа, гарын үсэг, засгийн асуудлыг онцгойлон үзэж тус тусын сайн хууль боловсруулах*, мэдээллийн технологийн шинэ үйлчилгээ, сүлжээний болон интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллага, тэдгээрт тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл, зохицуулалт болон бүх нийтийн үйлчилгээний үүрэг, бүх нийтийн хандалт, агуулгын зохицуулалт, компьютерийн сүлжээ, мэдээллийн системийн *тухай асуудлуудыг “Харилцаа холбооны тухай” хуулинд нэмж оруулан зохицуулах, энэ хуулийг “Харилцаа, Холбоо, Мэдээллийн Технологийн хууль”* хэмээн нэрлэх нь зүйтэй.
- Мэдээлэл Холбооны Технологийн (МХТ) хөгжлийг дэмжих талаар төрийн байгууллагуудын бүрэн эрх, үүрэг, хариуцах үндсэн байгууллага
- Хуулийн нийтлэг үндэслэл гэсэн бүлгийн 1-р зүйлийг “Хуулийн зорилт, хэрэглэх хүрээ” хэмээн өөрчлөн найруулах, энэ зүйлийн 1.1-д “өрсөлдөөнийг дэмжих, бүх нийтийн үйлчилгээ хандалтыг хангах, энэ зах зээлийг либеральчлах замаар зохицуулах” гэсэн заалт нэмэх, 1.2-ийг нэмж “цахилгаан холбооны сүлжээ, цахилгаан холбооны үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлага, уг шаардлагыг сахин мөрдөж буйд тавих төрийн хяналтын журмыг энэ хуулиар тогтооно” хэмээн найруулах нь зохистой. Мөн хувь хүний ашиг сонирхлыг

хамгаалах, мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах эрхийг хангах, ёс суртахууны хамгаалалт хийх талаар заалт оруулах шаардлагатай.

- Хуулийн 3 –р зүйлийн нэр томъёог олшруулах, дахин тайлбарлах шаардлагатай байна. Тухайлбал, “бүх нийтийн үйлчилгээ”, “дамжуулалтын сувгийг ашиглах”, “эцсийн төхөөрөмж”, “радио төхөөрөмж”, “телефоны дугаарлалт”, “хөдөлгөөнт радио үйлчилгээ”, “сүлжээнд хандах хандалт”, “дугаар”, “нийтийн зориулалттай сүлжээ”, “зохицуулалт”, “хиймэл дагуул”, “хиймэл дагуулын холбооны үйлчилгээ”, “телефон ярианы үйлчилгээ”, “цахилгаан холбоо”, “цахилгаан холбооны хэрэгсэл”, “цахилгаан холбооны шугам”, “мэдээллийн сүлжээ”, “холболтын сүлжээ” гэх мэт олон нэр томъёог нэмж тайлбарлах шаардлагатай байна.
- Төрийн байгууллагуудын бүрэн эрхийн тухай бүлэгт Үнэ тарифын бодлого, өрсөлдөөн, монополийн эсрэг, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар төрийн байгууллагын эрхийг нарийвчлан зааж өгөх хэрэгтэй байна. Мөн байгууллага бүрийн эрх мэдлийг маш тодорхой зааж өгөх, үүндээ орчин үеийн конвергенци, бүх нийтийн (универсаль) хандалт, үйлчилгээний хандлагыг харгалзан үзэх. Мэдээлэл, харилцаа, холбооны үйлчилгээг олон нийтэд хүртээлтэй болгох талаар заалт оруулж өгөх хэрэгтэй байна.
- “Үйлчилгээ” хэмээх шинэ бүлэг нэмж “Цахилгаан холбооны үйлчилгээ”, “Телефон холбооны үйлчилгээ”, “Бүх нийтийн үйлчилгээ”, “Радио холбоо”, “Телевизийн үйлчилгээ”, “Мэдээллийн үйлчилгээ” зэргийг тодруулж зохицуулсан зүйл ангиуд оруулах хэрэгтэй байна. Шинээр үүсэх үйлчилгээг “харилцаа, холбооны үйлчилгээ” хэмээн тооцож хуулинд нэмэлт оруулж байх эрхийг УИХ эдэлнэ хэмээн бүрэн эрхэд нь нэмж өгнө. Ингэснээр технологийн төвийг сахисан байдлыг хангаж чадна.
- Салбарын монополичлолыг хязгаарлах, либеральчлах зохицуулалт бий болгохын тулд “Цахилгаан холбооны сүлжээг ашиглах, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага” гэсэн бүлгийг нэмж “шударга, бүх нийтээр хүлээн зөвшөөрөх шаардлагуудыг тогтооход баримтлах зарчим”, “цахилгаан холбооны нийтийн сүлжээг ашиглахад тавих шаардлагууд”, “зах зээлд давамгайлах байр суурьтай аж ахуйн нэгж”, “Хүчтэй, жам ёсны монополь байгууллага”, “Монополийг хязгаарлах” тухай зүйлүүдийг оруулж өгнө. Ингэснээр Өрсөлдөх чадварын зарчмыг тусгаж монополь компаниуд бусдыгаа хязгаарлах аюулыг хязгаарлаж чадна. Эдгээр заалтууд нь бүх компанийг ижил байдалд оруулах, өрсөлдөх тэгш

боломжоор хангах боломжийг олгоно. Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлахын тулд Харилцаа, холбооны зохицуулах хорооны бүрэн эрхийг өргөтгөх шаардлага тулгарч байна.

- “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан” хэмээх 3-р бүлгийг “Бүх нийтийн үйлчилгээ үзүүлэх” хэмээн өөрчлөн нэрлэж “бүх нийтийн үйлчилгээ үзүүлэх үүрэг”, “Бүх нийтийн үйлчилгээг ашиглах, түүнд холбогдох төлбөр” гэсэн зүйл ангиудыг нэмж оруулах шаардлагатай.
- Тусгай зөвшөөрлийн тухай бүлэгт “үйл ажиллагаагаа эхлүүлэх”, “үйл ажиллагаагаа эхлүүлснийг бүртгэх”, “цахилгаан холбооны сүлжээ ашиглах эрх, цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэх”, “тусгай зөвшөөрөл олгох”, “тусгай зөвшөөрлийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр олгох”, “тусгай зөвшөөрлийг сэргээх”, “тусгай зөвшөөрлийн нөхцөлд өөрчлөлт оруулах”, “Дээд үнийн хязгаарыг тусгай зөвшөөрөлд зааж өгөх”, “техникийн зөвшөөрөл”, “техникийн зөвшөөрөл олгох”, “техникийн зөвшөөрөл олгохоос татгалзах”, “техникийн зөвшөөрлийг сэргээх”, “техникийн зөвшөөрлийн нөхцөлд өөрчлөлт оруулах”, “техникийн зөвшөөрлийн үйлчлэх хугацаа дуусах, хүчингүй болгох”, “Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлж болох үйлчилгээ” зэрэг зүйл ангийг нэмж оруулах шаардлагатай байна. Тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, техникийн зөвшөөрлийг бий болгосноор Цахилгаан холбооны салбарын либерализаци, бүтцийн өөрчлөлтийн хандлагыг цаашид хөгжүүлэх боломжтой болно. Мөн хэвтээ чиглэлд интеграцчилах хандлагыг тусгасан зүйл ангийг энэ бүлэгт юмуу өөр бүлэгт нэмж оруулах шаардлага байна. Дээрх хоёр бүлгийн нэмэлтүүд нь Үйлчилгээ болон сүлжээг тусад нь салгаж бие даасан аж ахуйн нэгжүүд байгуулахад үйлчлэх бөгөөд монопольчлол үүсэх боломжийг хаах зориулалттай.
- Хуулийн 6-р бүлэг болгон “Харилцаа, холбооны үйлчилгээг нийтэд хүртээмжтэй болгох” гэсэн бүлгийг нэмж “харилцаа, холбооны үйлчилгээ үзүүлэх үүрэг”, “Үйлчилгээний гэрээ байгуулах”, “Үйлчилгээний гэрээний нөхцөл”, “Эцсийн төхөөрөмжийг сүлжээнд холбох”, “Эцсийн төхөөрөмжийг ашиглах нөхцөл” гэх зэрэг зүйл ангийг нэмж өгнө.
- Дараа нь “Харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх” гэсэн бүлгийг нэмж “Цахилгаан холбооны үйлчилгээг хязгаарлах, түдгэлзүүлэх”, “Үйлчилгээний гэрээний үйлчлэлийг түдгэлзүүлэх, зогсоох”, “Үйлчилгээний гэрээний эрх, үүргийг шилжүүлэх”, “Нийтийн цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлдэг

байгууллага солигдсон тохиолдолд үйлчлүүлэгчийн эдлэх эрх”, “Цахилгаан холбооны сүлжээнд үүссэн гэмтлийг засах, арилгах”, “Түрээсийн шугамын үйлчилгээ үзүүлэх нөхцөл, үүрэг”, “Түрээсийн шугамын үйлчилгээг хязгаарлах, гэрээг дуусгавар болгох”, “Үйлчлүүлэгчийн тухай өгөгдлийг нийтлэх”, “Цахилгаан холбооны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон мэдээллийн аюулгүй байдал”, “Хууль хамгаалах байгууллагуудад мэдээлэл өгөх үүрэг” гэсэн зүйл ангийг оруулж өгнө.

- Дараа нь “Хамтын ажиллагаа болон харилцаа холбооны сүлжээнд хандах” гэсэн бүлэг нэмж өгөх боломжтой. Энэ бүлэгт харилцаа холбооны сүлжээний операторууд гэрээ байгуулах замаар сүлжээний харилцан холболтыг хэрхэн бий болгох, сүлжээ дундын нийцлийг бий болгох, гэрээ хэрхэн байгуулах тухай зохицуулалт орж ирнэ. Мөн харилцан холболт хийх талаар операторуудын (ялангуяа зах зээлд давуу байр суурь эзэлдэг) хүлээх үүргийг нэг зүйл анги болгон оруулна. Мөн “Харилцан холболтын төлбөр, харилцан холболтын үйлчилгээ”, “харилцан холболтоос үүссэн маргааныг шийдвэрлэх”, “нийтийн сүлжээнд хандах”, “телефоны сүлжээнд хандах онцгой хандалт”, “Нийтийн сүлжээнд хандах хандалтын төлбөр”, “Нийтийн сүлжээнд үйлчилгээ үзүүлэгчдийн хандах хандалтыг хязгаарлах”, “Хязгаарлалттай холбоотой үүссэн маргааныг шийдвэрлэх” гэсэн зүйлүүдийг оруулна.
- Энэ хуулинд үнэ тарифын асуудлыг маш бүрхэг оруулсан, зөвхөн ХХЗХ-оос тогтоосон нөхцөлийн дагуу тарифыг тогтооно гэсэн заалт байдаг. Үүнээс үзвэл үнэ тарифын асуудлыг маш тодорхой оруулж өгөх шаардлага байгаа нь харагдаж байна. Тиймээс “Харилцаа холбооны үйлчилгээ ашигласны төлбөр” хэмээх бүлэг нэмж “тарифын тухай мэдээлэл өгөх үүрэг”, “төлбөр тооцох”, “төлбөрт тавигдах шаардлага”, “хөнгөлөлт үзүүлэх боломж”, “зах зээлд давамгайлалч операторуудад тавигдах шаардлага”, “тарифыг хэрэглэх” гэх зэрэг зүйл ангиудыг оруулж болохоор байна.
- Монгол улс технологийн хувьд гадаадаас бүрэн хамааралтай, Харилцаа холбооны сүлжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд бүрэн найдвартай байж чадахгүй учир хэрэглэгчдийн болон ажиллагсдын аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хортой нөлөөлөл, цацрагийг тодорхойлох, хоорондын нийцэл, харилцан холболтыг хангах, хамтын ажиллагааг бий болгох зорилгоор импортоор авдаг тоног төхөөрөмжүүдэд тавигдах шаардлагыг тодруулсан бүлэг нэмэх шаардлагатай байна. Тухайлбал “Харилцаа холбооны сүлжээний тоног

төхөөрөмж” гэсэн бүлэг нэмж түүнд “Тоног төхөөрөмжийг импортлох (нийлүүлэх), ашиглалтад оруулахад тавигдах шаардлага”, “тоног төхөөрөмжид тавигдах шаардлага”, “Тоног төхөөрөмжийн нийцлийг үнэлэх”, “Тоног төхөөрөмжийг гэрчилгээжүүлэх”, “Шалган гэрчилгээжүүлэх байгууллага”, “Тоног төхөөрөмжийг сүлжээнээс салгах операторын эрх”, “Онцгой зориулалттай тоног төхөөрөмж”, “Тоног төхөөрөмжийн нийцэлд тавих хяналт” гэсэн зүйл ангийг томъёолон оруулж болохоор байна.

- Одоогийн хуулинд Радио холбооны тухай заалтууд байхгүй, зөвхөн сүлжээний тухай дурдаад өнгөрсөн, журмаар асуудлыг зохицуулж байгаа нь эрх зүйт төрийн шаардлагад нийцэхгүй байна. Тиймээс радио давтамжийг хуваарилах үндсэн зарчим, зорилго, ашиглалтын дэглэмийг тусгасан “Радио холбоо” гэсэн бүлэг нэмж “Радио давтамжийг хуваарилах төлөвлөгөө”, “Радио төхөөрөмжид тавигдах шаардлага”, “Радио холбооны дуудлага”, “Хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл, мэдээллийг замаас нь барих”, “цацах төхөөрөмжийг байрлуулах зөвшөөрөл”, “Зөвшөөрөл олгох”, “Зөвшөөрлийн нөхцөлд өөрчлөлт оруулах”, “Зөвшөөрлийг хүчингүй болгох”, “Шуугианаас хамгаалагдах баталгаа”, “Цацах төхөөрөмж ашиглах зөвшөөрөл”, “Ашиглах зөвшөөрлийг олгох, сунгах”, “Радио цацах төхөөрөмжийг ашиглах зөвшөөрлийг нөхцөлийг өөрчлөх”, “Зөвшөөрлийг түдгэлзүүлэх”, “Зөвшөөрлийг хүчингүй болгох”, “цацах төхөөрөмжийг хилээр оруулах”, “Радио холбоонд шуугиан үүсгэх”, “Сонирхогчийн радио холбоо” гэсэн зүйл ангиудыг оруулах шаардлагатай.
- Монгол улсад харилцаа холбооны дугаарлалт, адилтгах код, богино кодыг ашиглах үндсэн зарчим, зорилго, дэглэмийг тусгасан тусгай бүлэг оруулах бүрэн боломжтой. Энэ бүлэгт хамтын дугаарлалтын салбарт харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай дугаарлалт, адилтгах код, богино кодыг байршуулах зохицуулалтыг тодорхойлно.
- Сүүлийн бүлгийн өмнө “Харилцаа, холбооны салбарыг төрөөс зохицуулах” гэсэн бүлгийг нэмж “Харилцаа холбооны салбарт олон улсын байгууллагуудтай харилцах”, “Харилцаа холбооны салбарт төрийн хяналт хэрэгжүүлж буй төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”, “Заавар, зөвлөмж” (ХХЗХ-ны удирдах ажилтнуудаас илэрсэн дутагдлыг арилгах талаар өгч буй), “ХХЗХ-д мэдээлэл гаргаж өгөх үүрэг”, “Гомдол авч хэлэлцэх”, “Харилцаа холбооны системийн төрийн бүртгэл”, “ХХЗХ-нд тавих хяналт” гэсэн зүйл ангиудыг оруулж өгч болохоор байна.

- Үүнээс гадна Үнийн хязгаарлалт хийх тохиолдлуудыг зааж өгөх, Оюуны өмчийн хамгаалалтын асуудлуудыг тусгах, Тахир дутуу хүмүүсийн эрх ашгийг хамгаалах заалтууд оруулах, Бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгө дээр тулгуурлан хөдөө орон нутагт үнэгүй терминалууд бий болгох талаар зохицуулалт оруулах, Хөрөнгө, татаасын бодлогыг тусгах, Төр, хувийн салбарын түншлэлийн /Public Private Partnership/ асуудлыг тусгах, Локаль сүлжээний өрсөлдөөнийг төрөөс дэмжих асуудлыг тусгах, Өөрийн дэд бүтцээ байгуулж буй компанийг төрөөс хэрхэн дэмжихийг тодорхойлох, Радио давтамжийн зурвасыг үнэ хаялцуулан худалдах заалт оруулах, Орчин үеийн төлбөрт телевиз, хүсэлтээр үзүүлдэг видео /video on demand/-ын талаар заалт оруулах, Бага үнэтэй сүлжээ хөгжүүлэх, өөрийгөө зохицуулах зарчмыг захиргааны бүрэн эрхтэй зөв хослуулах, шинэ компанид сувгаа хэрэглүүлж буй компаниудад лиценз татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт стратегийн хөгжлийн баримжаалал тусгах шаардлага харагдаж байна.

МХХТ-ийн хуулийн төслийг боловсруулахдаа эдгээр асуудлыг оруулахаас гадна дараах зүйлсийг тусгаж өгөх шаардлагатай нь харагдаж байна. Тухайлбал:

- Орчин үеийн конвергенцийн хандлагын дагуу зохицуулах байгууллагын тоог цөөлөх, хамгийн зохистой бага хэмжээнд болгож цөөрүүлэх
- Хуулинд байгууллага бүрийн эрх мэдлийг маш тодорхой зааж өгөх, үүндээ орчин үеийн конвергенци, бүх нийтийн (универсаль) хандалт, үйлчилгээний хандлагыг харгалзан үзэх. Мэдээлэл, харилцаа, холбооны үйлчилгээг олон нийтэд хүртээлтэй болгох талаар заалт оруулах.
- МХХ-ны салбарын харилцаа болон оюуны өмчийн уялдаа холбооны асуудлыг тусгах. Харилцаа, Холбоо, Интернетийн сүлжээгээр дамжиж буй өгөгдөл мэдээлэл, веб сайтуудад тавигдсан агуулга, төрөл бүрийн өгөгдлийн оюуны өмчийн асуудал бараг зохицуулалтгүй орхигдсон байна. Зөвхөн “Оюуны өмчийн тухай” хуулинд хэдхэн бүдэг өгүүлбэр байгаа.
- Өнөөдөр монголын МХТ-ийн зах зээл дээр тоглогчид болох сүлжээний операторууд, үйлчилгээ үзүүлэгчид, үүрэн телефоны операторууд, хэрэглэгчид тодорхой болчихсон. Гэхдээ эцсийн эцэст энэ хэлхээний бүх оролцогчдын зардлыг эцсийн хэрэглэгч болон үйлчлүүлэгчид төлдөг. Үүнээс гадна энэ зах зээл дээр шинэ тоглогчид гарч ирж зах зээлийн хуучин аваргуудтай зөрчилдөөнд орж

эхэллээ. Тиймээс шинэ хуулинд хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалт оруулах зайлшгүй шаардлагатай.

- Хэдийгээр зах зээлийн оролцогчид ижил тэгш боломж нөхцөлтэй гэгдэж байгаа боловч бодит байдал дээр шинэ оролцогчдод маш хүнд байдаг. Тэд зах зээл дээрх оролцоогоо авч үлдэхийн тулд илүү их цаг хугацаа, санхүүгийн нөөц гаргах шаардлагатай болдог. Антенийн суурийг бүртгүүлэх, барих, операторын байр, байшинг барих, сүлжээ түрээслэхэд олон төрлийн саад бэрхшээл оршсоор байгаа. Тиймээс зөвхөн харилцаа холбоо төдийгүй мэдээллийн технологийн зах зээл дээрх чөлөөт өрсөлдөөнийг хангасан зохицуулалтыг энэ хуулинд сайн суулгаж, журмуудын хүнд сурталт зохицуулалтыг халах хэрэгтэй байна. Одоо байгаа журмуудын дагуу хэт зохицуулалт бий болсон, хоорондоо авцалдаа, уялдаагүй заалтууд их байгаа учир антени босгох газрын зөвшөөрөл авахын тулд 20 орчим гарын үсэг, зөвшөөрөл авах шаардлагатай байгаа. Энэ ажиллагаа нь дунджаар 100 орчим ажлын өдөр шаарддаг.
- Мэдээллийн болон холбооны орчин үеийн үйлчилгээг мэдээллийг тээх, дамжуулах, мэдээллийг хүргэх асуудал хэмээн үзэж болно. Энд дамжуулж буй мэдээллийн өмчлөх, эзэмших эрхийг хэрхэн дамжуулах, худалдах вэ? гэсэн асуудал гарч ирдэг. Тиймээс мэдээлэл, холбооны үйлчилгээ нь үнэн чанартаа оюуны өмчийн эрхийн зүйл болон хувирч байна. Ер нь харилцаа, холбоо, мэдээллийн технологийн салбарын зохицуулалт бүрэн дүүрэн биш, бүрхэг, хэрэгцээтэй олон заалт байхгүй учир операторууд нэг ойлголт, гэрээг янз бүрээр тайлбарлаж, ойлгох хандлага ч ажиглагдаж байна. Тиймээс эдгээр асуудлыг анхаарсны үндсэн дээр шинэ хуулийн төслөө боловсруулах ёстой.
- Орчин үеийн технологи хурдтай хөгжиж, конвергенцийн хандлага хөгжиж байгаагийн улмаас гар утсыг цэвэр холбооны хэрэгсэл гэж үзэхэд хэцүү болсонтой нэгэн адил компьютер, өврийн компьютерийн тооцоолон бодох хэрэгсэл гэж үзэж болохгүй боллоо. Гар утсаараа мэдээлэл татаж авч, Интернетэд зочилж болохын нэгэн адил компьютерээсээ дэлхийн аль ч улсруу ярьж болдог болсон. Тиймээс Харилцаа холбооны хуулинд мэдээллийн технологийн суурь зохицуулалтыг нэмж суулгахад ямар ч зөрчилдөөн үүсэхгүй.
- Мэдээллийн технологийн салбарын зах зээлийг бүтэцлэж, ангилсан эдийн засгийн үндэслэлтэй хандлагыг хуулинд тусгаж өгөх шаардлага байна. Мэдээллийн

технологийн зах зээл дээр ноёлож байгааг тогтоох шалгуурыг хуулинд оруулж өгөх нь зүйтэй.

- Мэдээлэл, харилцаа, холбооны технологийн салбар хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг хязгаарлах, тэдний хоорондын харилцан ажиллагааны зарчмыг хуулиар тогтоож өгөх ёстой.
- МХХТ-ийн үйлчилгээний хүртээмжтэй байдлын шалгуурыг хуулиар тодорхойлох шаардлага ч гарч ирж байна.
- Зохицуулалтын өрсөлдөөний загварыг хуулиар бататгаж өгөх хэрэгцээ бий болоод байна.